



ДУНДГОВЬ АЙМГИЙН
ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН
ТЭРГҮҮЛЭГЧДИЙН ТОГТООЛ

2012 оны 11 сарын 23 өдөр

Дугаар 130

Мандалговь

Аймгийн ЗДТГ-ын автомашинуудыг
худалдах тухай

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 77 дугаар зүйлийн 77.4. Аймгийн ИТХ-ын Тэргүүлэгчдийн 2010 оны 22 тоот тогтоолоор батлагдсан “Орон нутгийн өмчит хуулийн этгээдийн үндсэн хөрөнгө олж авах, бүртгэх, данснаас хасахад баримтлах журамын 3 дугаар зүйлийн 3.1“в” 3.2.6-гийн “а” заалтуудыг үндэслэн Аймгийн ИТХ-ын Тэргүүлэгчдээс ТОГТООХ НЬ:

1. Аймгийн ЗДТГ-ын ашиглагдаж байгаа 41-92 ДУА улсын дугаартай портер, ДУА 39-81 дугаартай Тоёото раун машинуудыг байгууллагын өмч хамгаалах комиссын дүгнэлт Мэргэжлийн хяналтын улсын байцаагчийн дүгнэлт зэрэг баримт бичигээр үндэслэн ажлын шаардлага хангахгүй болсон тул худалдахыг зөвшөөрсүгэй.

2. 1999 онд ашиглалтад орсон 41-92 ДУА улсын дугаартай портер маркын автомашиныг 1,0 сая төгрөг, 1998 онд ашиглалтанд орсон 39-81 ДУА улсын дугаартай Тоёото раун маркын автомашиныг 2,0 сая төгрөгөөр худалдах доод үнийг тогтоон дуудлагаар худалдсугай.

3. Автомашиныг хүлээн авч дуудлага худалдааг хууль тогтоомжийн дагуу явуулахыг Орон нутгийн өмчийн албанд даалгасугай.

ДАРГА



Ц.МӨНГӨНЦООЖ